

ОЛОН УЛСЫН ЭДИЙН ЗАСГИЙН ХАРИЛЦАА “МОНГОЛЫН НУУЦ ТОВЧОО”-НД ТУСГАЛАА ОЛСОН НЬ

Б. Мягмаржав*

Монголын нууц товчоонд (МНТ) эдийн засаг, түүний дотроос хөдөө аж ахуй, олон улсын эдийн засгийн харилцаа, мал аж ахуйн эдийн засгийн олон асуудал тусгагдсан байдаг. Нүүдлийн мал аж ахуй эрхэлж байсны үрээр Чингис хаан эзэнт гүрнээ байгуулж чадсан юм. Тэр үед малаа өсгөх, үржүүлэх, малын бэлчээрийг тэлэх зорилгоор худаг ус гаргаж, өртөө замд газарчин, улаачныг олноор ажиллуулах болжээ.

Монголын нууц товчооны 206, 234-р зүйлд адуучин, үхэрчин, тэмээчин, хоньчин, ямаачин, хургачин, унагачин, тугалчин зэрэг нэр олонтаа таарах нь тэр үед мал аж ахуйн үйлдвэрлэл ихээхэн өргөн цар хүрээтэй явагдаж үйлдвэрлэл нь төрөлжсөн болохыг харуулж байна.

Энд эдийн засгийн шинжлэх ухаанаас олон улсын эдийн засгийн харилцаатай холбоотой хэд хэдэн асуудлыг сонирхон үзэхийг зорилоо. Үүнд:

1. Монголын нууц товчоонд “Хятад, Тангуд Сартаул, Багдад ба Оросыг эзэлсэн нь” хэмээх бүхэл бүтэн бүлэг бий. Энэ бүлэгт 1211-1225 он хүртэлх хугацаанд дээрх нутагт болсон үйл явдлыг хамаарч байгаа юм. Монголын нууц товчооны 274-р зүйлд Чормагын Хорч Бат, Бүри, Гүюг, Мөнх тэргүүтэн Боломан, Киев хотыг дагуулан Солонгосыг эзлэхээр явсан Жалор дайчны хойноос Есүдэр Хорчийг явуулсан зэрэг баримтууд бий.

Академич Ш.Нацагдорж Чингис хааны дэлхийн хэмжээний их гүрэн байгуулах гэсэн концепц, үзэл баримтлалыг шинэ зүйл гэж үзсэн байна. Өгөөдэй хааны үед эзэнт гүрний хил хязгаар олон орноор хүрээгээ тэлсэн байна. “Монголын эзэнт гүрэн 1260-аад оны үеэс Монгол, Түвд, Хятадыг багтаасан Юань улс, Дундад Ази, Дорнод Туркестаныг хамарсан Цагаадайн улс, Иран, Ирак, Өвөр Кавказыг эзэлсэн Хулагугийн буюу Иль хаадын улс, Кипчакийн тал, Өмнөд Орос дахь Алтан ордны улс гэсэн

* ШУА, Нүүдлийн соёл иргэний олон улс судлалын хүрээлэнгийн доктор, профессор

дөрвөн том улсад хуваагджээ" гэж доктор Ж.Гэрэлбадрах тэмдэглэсэн байна. Энэ бүгд МНТ олон улсын судлагдахуун болохыг харуулж байна.

2. МНТ-ны 202-р зүйлд 1206 онд Тэмүүжин далай хаанд өргөмжлөгдөж 95 мянган ноёдыг томилсон байдаг. Тэд зуу орчим мянган цэрэг удирдаж байсан бөгөөд ингэснээр олон улс дамжсан хүн амын шилжих хөдөлгөөн үүснэ гэсэн үг. Үүнд зөвхөн цэрэг эрс биш, хоол хүнсийг нийлүүлэх агтчин, бас бус албат хүмүүсээр энэ тоо нэмэгдэнэ. Энэ бол олон улсын хооронд хүн хүч шилжих нэгэн үндэс болж байна.

3. Хүн амын шилжилтийг дагаж олон тооны агт морьд, ачаа тэмээ, үхэр, шөлний хонь гээд мал адгуус, эд хөрөнгө зохих хэмжээнд дагалдана. Доктор Т.Содной "Чингэс хааны байлдан дагуулал харь улс орнуудад довтлохдоо дан ганц цэрэг эрс, унасан морьтой явж байсан биш, үй түмэн монголчууд гэр бүл, мал сүрэгтэйгээ аян дайн нүүдэл хийж байсан төдийгүй эзлэгдсэн улс орнуудын мал сүрэгтэй монгол үүлдрийн мал ч холилдон үржиж байсан" гэж тэмдэглэжээ. Үнэхээр тийм юм. Нууц товчооны 274-р зүйлд Өгөөдэй хаан "Чормаган Хорч тэр газарт захирагч (тамгач) болж, шар алт, шармал чимэг, хоргой, магнаг, хивс, торго, сувд, тана, урт хүзүүтэй өндөр хөлтэй аргамаг морь, ачааны тэмээ, луус зэрэг юмыг жил бүр хүргэн ирүүлж байсугай" хэмээн зарлиг болгосон байна. Энэ бол нэг төрлийн татвар болж байсан юм. Түүнээс гадна олон улсын хоорондын үйлдвэрлэлийн хүчин зүйлийн шилжилт мөн.

4. МНТ-ны 279-р зүйлд хаан зүг зүгийн мянгатаас замчин, улаачин гаргаж, суурь суурьт өртөө тавих тухай хэлснийг Цагаадай ах зөвшөөрч "Би эндээс Батад элч илгээе, Бат угтуулан өртөө зам байгуулж холбогтун" гээд өгүүлсэн нь: "Бүгдын хооронд өртөө зам тавъя гэдэг зөвөөс зөв" гэжээ. Морин өртөө олон улс хоорондын харилцааны томоохон түшиц газар болж байв. Морин өртөөнд эцсийн, завсрын, зангилаа гэж нэрлэгдэх буудлууд байжээ. Нэг буудлаас гарсан өртөөчин дараагийн буудалд сульдсан морио юулж, түр амран тэнхэрсэн морь унаж, дараагийн буудлыг зорино. Энэ мөчлөгийг тавьсан зорилгоо биелүүлтэл олонтоо давтана.

Орчин үеийн цахилгаан холбоонд эцсийн, завсрын, зангилаа гэх станцууд байдаг. Цахилгаан холбоо үүсэж хөгжсөн хугацаа 170 орчим жил бол морин өртөө 800 гаруй жилийн түүхтэй. Ийм учраас орчин үеийн цахилгаан холбоо морин өртөөний зохион байгуулалтын ерөнхий зарчимд тулгуурлан хөгжиж байна гэж монгол судлаачид үзэж байна. Морин өртөөгөөр элч чөлөөтэй явж харилцаа холбоо төдийгүй олон улсын худалдаа наймаа өргөжин хөгжиж байлаа.

5. МНТ-ны 260-р зүйлд "Зүчи, Цагаадай, Өгөөдэй гурван хөвгүүн, Өргэнчи хотод орж гурвуул олон хот ба иргэнийг хуваан авсан" гэж бичсэн байдаг. Энд газрын харилцаа зөвхөн Монгол нутгаар тогтохгүй олон улсын хүрээг хамарсан чухал асуудал болж байсан нь тодорхой байна. Академич Ш.Нацагдорж "Чингисийн байлдан дагууллын үр дүнд олон орны улс төрийн бутархай байдлыг зогсоов" гэж тэмдэглэсэн байна.

6. Чингис хааны байлдан дагууллын нэгэн шалтгааныг улс хоорондын бараа таваарын (таваар гэдэг нь эдийн засгийн нэр томьёо МНТ-ны 238, 273-р зүйлд бий) эрэлт, нийлүүлэлттэй судлаачид холбон тайлбарласан байдаг. Академич Ш.Нацагдорж "Чингис хаан Мухамедэд 3 удаа худалдаачин оролцсон элч илгээж худалдааны харилцаа тогтоохыг оролдсон боловч түүний санаснаар болсонгүй" гэж тэмдэглэсэн байдаг. МНТ-ны 254-р зүйлд Чингис хааны Сартаул иргэнд явуулсан Ухуна тэргүүтэн 100 элч алагдсанд ихэд өшиж Сартаул улстай байлдахаар шийдсэн байдаг.

7. Чингис хаан худалдаачдыг дэмжин, тэднийг хамгаалан, өртөө улаагаар чөлөөтэй зорчуулдаг байсан нь олон улсын хооронд худалдаа, арилжаа хөгжихөд таатай нөхцлийг бүрдүүлжээ.

8. МНТ-г хамарсан он жилүүдэд дэлхийн хоёр томоохон тив, олон улс орныг хамарсан худалдаа, арилжаа өргөжиж байсан нь нэгдмэл зах зээлийн эрэл хайлт эхэлсэн үе гэж үзэх үндэстэй бөгөөд хожим Хубилай хааны үед дэлхийд анх удаа цаасан мөнгө гүйлгээнд гарсан гэж судлаачид үздэг билээ.

"Чингисийн байлдан дагууллын үр дүнд тогтсон Монголын их гүрэн нь дорно дахин, өрнө дахиныг холбох аж ахуй, соёл хүмүүнлэгийн талаар нэгдэж үйлдвэрлэх хүчин, соёл иргэншлийн интеграц шинэ

шатанд шилжин орох, ялангуяа худалдаа соёлын харилцаа хөгжих бодит нөхцлийг бүрдүүлэв" гэж академич Ш.Нацагдорж хэлсэн билээ.

Энд олон улс хооронд технологийн шилжилт хэрхэн явагдаж байсан болон олон улсын менежмент, даяарчлалын асуудлыг хамруулж болох байна. МНТ-д хамрагдах тэрхүү цаг хугацаанд Гуулин (Солонгос) улсаас Хятад болон Монгол улсад дэрс, зэгсээр цаас хийх технологи нэвтэрч байжээ. Монгол улсын Сэлэнгэ аймгийн нутаг дахь Орхоны Цантын туурь үүний жишээ НСИСОУХ-ээс 2000-2001 онд зохиосон Монгол улс, БНХАУ, ОХУ-ын олон улсын хамтарсан экспедицд миний бие оролцож байх үедээ цаас хийдэг үйлдвэрийн туурьтай БНХАУ-ын ӨМӨЗО-нд тус тус таарч байсан бөгөөд Гуулин улсад цагаан будааны сүрлээр цаас хийдэг байжээ. Энэ технологи зөвхөн Хятад төдийгүй Монгол улсад нэвтэрч байсан байна. Энэ бол үйлдвэрлэлийн салбар дахь улс хоорондын технологийн дамжуулалт бөгөөд харин Чингис хааны үеийн цэргийн салбарт нэвтэрсэн технологи нилээд сайн судлагдсан юм.

9. Олон улсын худалдаа, олон улсын хооронд үйлдвэрлэлийн хүчин зүйлийн шилжих үйл явцын нэг болох цаасан мөнгө, олон улсын болон дэлхийн нэгдмэл зах зээл зэрэг МНТ-нд тусгалаа олсон олон улсын эдийн засгийн харилцааны олон талт асуудлууд нь Чингис хаан, түүний залгамжлагчид дэлхийн эдийн засаг болон зах зээлийг бий болгоход жинтэй хувь нэмэр оруулсан гэдэг дүгнэлтэд аргагүй хүргэж байна.

Японы нэрт монголч эрдэмтэн доктор Окада Хидэхиро "Монголын эзэнт гүрэн байгуулагдахаас өмнө дэлхийд Европ, Хятад гэсэн хоёр соёл иргэншил байлаа. Гэтэл Монголын эзэнт гүрэн байгуулагдсанаар Ази, Европ хоёр тивийг нэгтгээд Монголын гэсэн ганц соёл иргэншлийг бий болгосон. Ингэхлээр дэлхийн түүх Монголоос эхэлсэн гэж би үзэж байгаа юм" гэж хэлсэн билээ. Алдарт эрдэмтэн Окада Хидэхирогийн энэхүү гайхамшигт дүгнэлтийг судлаач миний бие нэн талархаж санаа нэг байгааг онцлон тэмдэглэж байна. Харин Монголын эзэнт гүрэн ба даяаршлын асуудлаар академич Ш. Бирагийн олон бүтээлүүдэд бичсэн нь олны анхаарлыг ихээхэн татаж байгааг тэмдэглэе.

1. Олон улсын эдийн засгийн шинжлэх ухаан цогц хэлбэрээр бүрэлдэн тогтохоос бүр өмнө хэдэн зууны тэртээ Чингис хаан олон улсын эдийн

засгийн харилцааны чухал элементүүдийг хэрэгжүүлж байсан нь МНТ-нд тусгалаа олжээ.

2. МНТ-нд олон улсын худалдаа, олон улс хооронд үйлдвэрлэлийн хүчин зүйлс шилжих (хүн, мал, эд хөрөнгө) татвар, таваар технологийн дамжуулалт, олон улсын менежмент зэрэг олон чиглэл тусгалаа олжээ.

3. Чингис хааны эзэнт гүрний үеийн олон улсын эдийн засгийн харилцааны олон талт үйл ажиллагаа нь олон улсын болон дэлхийн аж ахуй бий болоход үнэтэй хувь нэмэр болжээ.

4. Цаашид Чингис хааны эзэнт гүрний үеийн олон улсын харилцааны асуудлыг тал бүрээс нь шинжлэх нь түүхийн төдийгүй өнөө үед Ази, Африкийн олон оронд оршоор байгаа нүүдэлчид, нүүдлийн аж ахуйг харьцуулан судлах нь онол практикийн ач холбогдол бүхий асуудал тул энэ чиглэлийн судалгааг хөгжүүлэх нь зөвхөн түүхэн төдийгүй эдийн засгийн шинжлэх ухаанд ихээхэн ач холбогдолтой зүйл болно.

Жич: ШУ-ны доктор, профессор Б.Мягмаржавын энэ өгүүллэг "Өнөөдөр" сонины 2005-8-31 ны дугаарт нийтлэгдсэн бөгөөд манай сэтгүүлийн редакци уул өгүүллийг бүрэн эхээр нь дахин нийтэлж байна.